



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 1,172,278,239.00 (нэг тэрбум нэг зуун далан хоёр сая хоёр зуун далан найман мянга хоёр зуун гучин есөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори, оффисын барилгыг Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга К.Болат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан бүртгэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн  
140 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БАРЬСАН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил   | Төсөл, арга хэмжээний хүчин чадал | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/   | Улсын комиссын актын дугаар |
|-----|--|-----------------------------------|--|-----------------------------|
| 1   | Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори, оффисын барилга байгууламж (Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 11-р хороо) | 744 м.кв                          | 1,172,278,239.00   | 2019.10.25                  |
|     | Нийт дүн   |                                   | 1,172,278,239.00<br>(нэг тэрбум нэг зуун далан хоёр сая хоёр зуун далан найман мянга хоёр зуун гучин есөн) |                             |